

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ 2002 ОНД

Б.Даваахүү, ҮСГ-ын Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах мэргэжилтэн

Аливаа улс орны эдийн засгийн хөгжил, иргэдийнх нь аж байдал, амьжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй зохих ёсоор холбоотой байдаг. Өндөр боловсролтой, ажиллах ур чадвартай ажиллах хүч бол тухайн улс орны хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл билээ. Тухайн орны ажиллах хүч, ажил эрхлэлтийн байдал нь хүн амын насны бүтцээс шууд хамааралтай байдаг. Жил бүр хөдөлмөрийн насанд шилжиж байгаа хүний тоо, хөдөлмөрийн наснаас гарч байгаа хүний тооны зөрүү нь хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүний цэвэр өсөлтийг харуулдаг. Хэдийгээр манай оронд жил бүр ажиллах хүчин буюу эдийн засгийн идэвхитэй хүн амын өөрчлөлтийн талаар мэдээ гардаг боловч энэ нь ажиллах хүчний талаар нарийн мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж чаддаггүй билээ. 2002 онд Монгол улсын Статистикийн төв газраас ажиллах хүчний талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах, цаашилбал аливаа бодлого хөтөлбөрийн суурь тоо баримт болохуйц мэдээлэл бүрдүүлэх зорилгоор ажиллах хүчний судалгаа хийсэн байсан. Энэхүү судалгаагаар, Монгол Улсын хүн амын чухам хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхлэдэг хүн ам буюу ажиллагчид, ажилгүйчүүд, ажил эрхлээгүй хүн амын тоо хэд байгаа, хүн ам зүйн ачаалал, ажиллах хүчний хөдөлмөр оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин ямар байгааг харуулж, ажиллах хүчин, ажилгүйдлийн түвшний нийт эдийн засаг, үйлдвэрлэлийн түвшинд нөлөөлөх нөлөөллийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгсөн.

Оршил

Энэхүү судалгаанд Монгол Улсын хүн амын чухам хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхлэдэг хүн ам буюу ажиллагчид, ажилгүйчүүд, ажил эрхлээгүй хүн амын тоо хэд байгаа, хүн ам зүйн ачаалал, ажиллах хүчний хөдөлмөр оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин ямар байгааг харуулж, ажиллах хүчин, ажилгүйдлийн түвшний нийт эдийн засаг, үйлдвэрлэлийн түвшинд нөлөөлөх нөлөөллийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгөхийг зорилоо.

Хүн амын ажил эрхлэлтийн судалгааны үзүүлэлтүүдийг сум, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа (Монгол улсын харьяат, манай улсад удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын болон цагаач иргэд) суурин хүн амаар гаргадаг. Судалгааг сум, хорооны Засаг дарга нар гаргаж, аймаг, нийслэлийн

статистикийн албадаар шалгуулан Үндэсний Статистикийн Газарт авч нэгтгэгдэн гаргаж байна.

Судалгаанд орсон ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхэлдэг хүн ам, ажилгүйчүүдийг ҮСГ-ын дарга, НХХ-ийн сайдын 2002 оны 207/203 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хүн амын хөдөлмөр эрхлэлт болон ажиллах хүчний тухай үндсэн ойлголт, тодорхойлолт”-ын дагуу тодорхойлон гаргасан нь 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажиллагчид, ажилгүйчүүдийг тодорхойлсон аргачлалаас зөрүүтэй тул тоо нь өөр өөр байгааг өмнөх тайлбарт дурьдсан.

Судалгаанд орсон үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолт, тооцсон аргачлал

Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам - энэ нь олон улсын хөдөлмөрийн байгууллагын аргачлалын дагуу ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тооны нийлбэр юм. Эдийн засгийн идэвхитэй хүн амыг урт хугацаагаар буюу хуанлийн жилээр хэмжигдэх байнгын идэвхитэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхитэй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлдог. Энд орсон ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам нь “байнгын идэвхи” гэсэн ойлголтонд тулгуурласан ба нөгөө талаар Монгол Улсын хуулиар тогтоосон хөдөлмөрийн насны хүрээнд багтах хүн ам тул 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын үед хэрэглэсэн “тухайн үеийн идэвхи”-ээр тодорхойлсон эдийн засгийн идэвхитэй хүн амаас зөрүүтэй учир тоо нь өөр өөр байгаа болно. Хөдөлмөрийн насны ажилладаггүй, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлгүй хүмүүс, хөдөлмөрийн насны суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол хүмүүс ажиллах хүчинд хамрагдаагүй болно.

Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид - Аж ахуйн нэгж, байгууллагын орон тоонд ажиллагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хамтран ажил гүйцэтгэгчид, цалин хөлстэй өрхийн аж ахуй эрхэлдэг хүмүүс мөн ажилтай мөртлөө тодорхой шалтгаанаар (өвчтэй, цаг агаарын байдал, амралт г.м.) ажиллаагүй хүмүүс хамрагдсан. Энд ажил эрхэлдэг хүн ам “байнгын идэвхи” гэсэн ойлголтоор орсны зэрэгцээ насны хувьд хөдөлмөрийн насны хязгаартай тул 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын “тухайн үеийн идэвхи” –ээр тодорхойлсон “сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн” хүн амын тооноос зөрүүтэй болно.

Ажилгүйчүүд - энд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, хөдөлмөр эрхлэх боломжтой, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүсийг оруулсан. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын ажилгүйчүүдийн ойлголтонд бүртгэлтэй болон бүртгэлгүй ажил хайж байгаа гэж хариулсан 15 ба түүнээс дээш насны бүх хүн хамрагдсан тул энд дурьдсан бүртгэлтэй, хөдөлмөрийн насны ажилгүйчүүдээс ялгаатай болно.

Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин - Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан хувь.

Ажил эрхлэлтийн түвшин - Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан хувь.

Ажилгүйдлийн түвшин - Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхитэй хүн амд харьцуулсан хувь.

Хүн ам зүйн ачаалал - Хөдөлмөрийн насны нэг хүн амд ногдох хөдөлмөрийн насанд хүрээгүй, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүний тоо

Хөдөлмөр эрхлээгүй хүн ам - Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин, хөлс, орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тодорхой шалтгаангүй г.м) шалтгаанаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн ам. Гэхдээ эдгээрт бүх шатны сургуульд өдрөөр суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүмүүс ороогүй.

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам - Хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэнмөсөн алдсан нь тогтоогдсон тахир дутуу болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүс.

Хөдөлмөрийн насны суралцагчид - Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, 6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтанд хамрагдагчид, ЕБС-д суралцаж буй иргэд орно. Орой ба эчнээгээр суралцагчид, 6 сараас доош хугацаагаар суралцаж байгаа ажиллагчид нь тухайн байгууллагынхаа ажиллагчдын тоонд ордог тул тэдгээрийг суралцагчдад оруулахгүй.

Судалгааны товч агуулга

Энэ судалгааны гол зорилго нь эдийн засгийн идэвхитэй хүн амыг тодорхойлж, түүнээсээ ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин, ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшинг тооцож олон улсын түвшинтэй зэрэгцүүлэхэд оршино. Эдгээр үзүүлэлтүүдийг улсын түвшинд тооцохоос гадна аймаг, нийслэл, насны бүлэг, хүйсээр гаргасан. Мөн судалгаанд ажиллагчдыг боловсролын түвшин, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангиллаас гадна ажилладаг байгууллагынх нь төрлөөр, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй болон ажил хөдөлмөр эрхлээгүй хүн амыг шалтгаан, насны бүлгээр нь харууллаа.

Аливаа улс орны эдийн засгийн хөгжил, иргэдийнх нь аж байдал, амьжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй зохих ёсоор холбоотой байдаг. Өндөр боловсролтой, ажиллах ур чадвартай ажиллах хүч бол тухайн улс орны хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл билээ. Тухайн орны ажиллах хүч, ажил эрхлэлтийн байдал нь хүн амын насны бүтцээс шууд хамааралтай байдаг. Жил бүр хөдөлмөрийн насанд шилжиж байгаа хүний тоо, хөдөлмөрийн наснаас гарч байгаа хүний тооны зөрүү нь хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүний цэвэр өсөлтийг харуулдаг. Хөдөлмөрийн насанд шилжих хүний тоо нь тайлант жилээс 15 жилийн өмнөх төрөлтийн түвшин, нялхсын болон хүүхдийн нас баралтын тухайн үеийн хугацааны түвшингээс хамаардаг билээ.

Хүснэгт 1. Хүн амын насны бүтэц*

Хүн амын насны бүтэц	Хүн амын тоо, мян.хүн				Өсөлт, бууралт				Нийт хүн амд эзлэх хувь			
					2002		2002					
	1999	2000	2001*	2002*	1999	2000	2001	%	1999	2000	2001	2002
Суурин хүн ам - бүгд	2313.2	2379.5	2398.7	2432.2	105.1	102.2	101.4		100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:												
16 хүртэл настай	871.2	872.1	860.4	852.8	97.9	97.8	99.1		37.7	36.7	35.9	35.1
Хөдөлмөрийн насны (16-54 настай эмэгтэй, 16-59 настай эрэгтэй)	1279.2	1347.4	1402.8	1439.2	112.5	106.8	102.6		55.3	56.6	58.5	59.2
Хөдөлмөрийн нас хэтэрсэн (эмэгтэй 55, эрэгтэй 60-аас дээш настай)	162.8	160.0	135.5	140.2	86.1	87.6	103.5		7.0	6.7	5.6	5.8

Тайлбар: * Хөдөлмөрийн хуулийн дагуу 2001, 2002 оны хөдөлмөрийн насны хүн амыг хүйс харгалзахгүйгээр 16-59 насаар авсан болно.

Эх сурвалж: ҮСГ, 2002

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2002 онд 1999 оныхоос 12.5 хувь, 2001 оныхоос 2.6 хувь өссөн байхад энэ хугацаанд суурин хүн амын тоо 1999 оныхоос 5.1 хувиар, 2001 оныхоос 1.4 хувиар тус тус өссөн байна. Үүнээс үзэхэд хөдөлмөрийн насны хүн амын тоо нийт хүн амын тооноос илүү хурдацтай өсч ирсэн нь харагдаж байна. Иймээс хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэхэд энэ онцлогийг харгалзан үзэх нь чухал юм.

Улс орнууд хүн амынхаа хөгжлийн ирээдүйн хандлагыг урьдчилан тодорхойлохдоо хүн ам зүйн ачааллыг харгалзан үздэг. Манай улсын хүн ам зүйн ачаалал бага зэрэг буурах хандлагатай байна. Манай улсад хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны нэг хүнд ногдох тэжээлгэгч хүний тооны харьцаа 1999 онд 0.81 байсан бол 2000 онд 0.77, 2001 онд 0.71, 2002 онд 0.69 байна. Зах зээл өндөр хөгжсөн орнуудад энэ үзүүлэлт дунджаар 0.50 орчим байдаг. Хүн ам зүйн ачаалал хэт өндөр байх нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар ард түмний аж байдлыг дээшлүүлэхэд зарим сөрөг нөлөөтэй байдаг тул аливаа улс орны хүн ам зүйн бодлогын гол асуудлуудын нэг нь энэхүү ачааллыг

зохицуулах явдал байдаг. Хүн ам зүйн ачааллын үзүүлэлтийг зарим тохиолдолд ажил эрхэлж байгаа нэг хүнд ногдох тэжээлгэгч хүний тоогоор илэрхийлдэг. Үүнийг тооцож үзвэл 1999 онд ажил эрхэлж байгаа нэг хүнд ойролцоогоор 1.3 тэжээлгэгч ногдож байсан бол 2002 онд 1.1 болж ачаалал 0.2 пунктээр буурсан байна.

Хүснэгт 2. Хүн ам, ажил эрхлэлтээр

Хүн ам, ажил эрхлэлтээр	(жилийн эцэст, мян.хүн)						
	1999	2000	2001	2002	$\frac{2002}{1999}$	$\frac{2002}{2000}$	$\frac{2002}{2001}$
					%	%	%
1. Хөдөлмөрийн насны хүн амын тоо	1279.3	1347.4	1402.8	1439.2	112.5	106.8	102.6
2. Ажиллах хүч	853.4	847.6	872.6	901.7	105.7	106.4	103.3
3. Ажиллагчид*	813.6	809.0	832.3	870.8	107.0	107.6	104.6
4. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүд	39.8	38.6	40.3	30.9	77.6	80.1	76.7
5. Ажил эрхлээгүй хүн ам	208.6	282.7	278.9	265.8	127.4	94.0	95.3
6. Хөдөлмөрийн насны суралцагчид	149.5	153.7	175.1	196.5	156.7	127.8	112.2
7. Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин (%)	66.7	62.9	62.2	62.7	94.0	99.7	100.8
8. Ажил эрхлэлтийн түвшин (%)	63.6	60.0	59.3	60.5	95.1	100.8	102.0
9. Ажилгүйдлийн түвшин (%)	4.7	4.6	4.6	3.4	72.3	73.9	73.9

Тайлбар: * Гадаадад гэрээгээр болон Гадаад хэргийн яамны шугамаар ажиллаж байгаа хүмүүс ороогүй болно.

Эх сурвалж: УСГ, 2002

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхитэй байдлыг харуулдаг гол үзүүлэлт бол ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин юм. Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин нь ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан хувь юм. Энэ үзүүлэлт сүүлийн үед тогтмол буурч ирсэн бол 2002 онд улсын дундаж 62.7 хувь болж, өмнөх оноос 0.5 пунктээр өссөн.

Ажиллах хүчний тоо буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам нь ажил эрхэлж байгаа хүний болон бүртгэлтэй ажилгүйчүүдийн тооны нийлбэр учраас энэ хоёр үзүүлэлтээс шууд хамаардаг.


Нэг талаас 2002 онд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 23.3 хувиар буурч, нөгөө талаас хөдөлмөрийн насны хүн амын тоо өмнөх оныхоос 2.6 хувиар, ажил эрхлэгчдийн тоо 4.6 хувиар тус тус өссөнөөс голлон шалтгаалж ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин өссөн нь харагдаж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 3. Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин, аймаг, нийслэлээр (хувиар)

Аймаг, нийслэл	1999	2000	2001	2002	Өсөлт, бууралт (%)		
					2002	2002	2002
					1999	2000	2001
Архангай	78.8	78.7	77.0	76.6	97.2	97.3	99.4
Баян-Өлгий	72.8	65.4	71.6	67.9	93.3	103.9	94.8
Баянхонгор	82.8	81.8	78.4	70.7	85.4	86.5	90.2
Булган	68.2	72.1	67.2	68.1	99.9	94.4	101.4
Говь-Алтай	83.0	83.6	78.6	78.2	94.2	93.5	99.4
Дорноговь	65.1	65.0	67.2	66.0	101.4	101.5	98.2
Дорнод	48.7	47.0	46.0	45.2	92.8	96.2	98.2
Дундговь	84.4	83.0	81.1	80.6	95.5	97.2	99.4
Завхан	80.8	80.8	79.7	78.5	97.1	97.2	98.6
Өвөрхангай	85.6	86.0	81.8	77.9	91.0	90.6	95.3
Өмнөговь	91.0	90.5	89.4	81.9	90.0	90.4	91.6
Сүхбаатар	77.3	77.3	77.0	77.5	100.2	100.3	100.6
Сэлэнгэ	62.2	61.2	61.8	64.1	103.0	104.7	103.7
Төв	67.5	73.2	75.4	75.6	112.1	103.4	100.3
Увс	71.5	77.1	78.2	77.7	108.7	100.7	99.3
Ховд	71.6	73.1	68.9	69.1	96.5	94.6	100.3
Хөвсгөл	77.1	73.8	72.8	71.9	93.2	97.4	98.7
Хэнтий	64.2	68.5	68.4	67.6	105.3	98.7	98.9
Дархан-Уул	51.8	45.6	46.7	43.2	83.5	94.8	92.5
Улаанбаатар	54.3	46.2	45.9	50.4	92.8	109.1	109.8
Орхон	73.1	69.6	68.7	64.6	88.3	92.8	94.1
Говьсүмбэр	56.2	59.0	53.0	53.7	95.5	91.0	101.3
Улсын дундаж	66.7	62.9	62.2	62.7	94.0	99.7	100.8

Эх сурвалж: ҮСГ, 2002

2002 оны байдлаар Төв, Ховд, Сүхбаатар, Говьсүмбэр, Булган, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотод ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин 0.3–9.8 хувиар өсч, харин бусад аймгуудад 0.6–9.8 хувиар буурсан байна.



Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшинг хүйс, насны бүлгээр нь авч үзэхэд эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин 25–34 насны бүлэгт эрэгтэйчүүдийнхтэй ойролцоо, 35-49 насны бүлэгт эрэгтэйчүүдийнхээс өндөр, бусад насны бүлгүүдэд харьцангуй доогуур байна. Ялангуяа 16-25 насанд эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс ихээхэн доогуур байгаа нь энэ насны бүсгүйчүүд эрэгтэйчүүдээс харьцангуй олноороо суралцаж байгаатай холбоотой юм.

Хөдөлмөрийн насны нийт хүн амд хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн амын эзлэх хувийн жин 2001 онд 93.7 хувь байсан бол 2002 онд 94.0 хувь болж өсөв. Энэ нь хөдөлмөрийн насных боловч хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2001 онд 88.2 мянга байснаа 2002 онд 85.8 мянга болж буурсантай холбоотой. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн амд хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан нь тогтоогдсон тахир дутуу болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүсийг хамруулсан.

Хүснэгт 4. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүний тоо, шалтгаанаар

Шалтгаан	1999	2000	2001	2002	$\frac{2002}{1999}$	$\frac{2002}{2000}$ %	$\frac{2002}{2001}$
Бүгд	79781	77911	88172	85756	107.5	110.1	97.3
Тахир дутуу	28124	32900	41212	42532	151.2	129.3	103.2
Тэтгэвэрт гарсан	51657	45011	46960	43224	83.7	96.0	92.0
- 4 ба түүнээс дээш хүүхэдтэй	19788	20468	20786	18202	92.0	88.9	87.6
- хөдөлмөрийн нөхцөлөөр	9787	7766	9574	8733	89.2	112.5	91.2
- онцлог мэргэжил, цэргийн байгууллагад ажилласан	6533	5368	4537	6168	94.4	114.9	135.9
- ажилласан хугацаагаар	15549	11409	12063	10121	65.1	88.7	83.9


Эх сурвалж: УСГ, 2002

2002 онд хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн амын 49.6 хувь буюу 42.5 мянган хүн тахир дутуу, 50.4 хувь буюу 43.2 мянга нь тэтгэвэрт гарсан хүмүүс байна. Нийт тэтгэвэрт гарсан хүмүүсийн 42.1 хувь нь 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, 23.4 хувь нь ажилласан жилээрээ, 34.5 хувь нь хөдөлмөрийн нөхцөл болон цэргийн байгууллагад ажилласан жилээрээ тэтгэвэрт гарагчид байна.


Хөдөлмөрийн насны суралцагчид 1999 онд 149.5 мянга байсан бол 2002 онд 196.5 мянга болж, 31.4 хувь өссөн байна.

Ажиллагчдын тоо 2002 онд 870.8 мянга болж (Хүснэгт 2), 2001 онтой харьцуулахад 4.6 хувь буюу 38.5 мянган хүнээр нэмэгдлээ.

Ажиллагчдыг насны бүлгээр нь авч үзэхэд нийт ажиллагчдын дотор 20 хүртэлх насны залуучуудын эзлэх хувийн жин жилээс жилд өсч, 2002 онд 1992 оныхоос бараг 1.5 дахин нэмэгдсэн бол, 20–34 насны ажиллагчдын хувийн жин 2.1–4.5 пунктээр буурч, харин 35-44 болон 45 ба түүнээс дээш насных 0.8-2.5 пунктээр тус тус нэмэгдсэн байна.



2002 онд нийт ажиллагчдын 9.6 хувь буюу 83.5 мянга нь 20 хүртэлх настай, 15.1 хувь буюу 131.7 мянга нь 20–24 настай, 32.4 хувь буюу 282.4 мянга нь 25–34 настай, 26.2 хувь буюу 227.9 хувь нь 35–44 настай, 16.7 хувь буюу 145.3 мянга нь 45 ба түүнээс дээш настай хүмүүс байна. Ажиллагчдын хүйсийн бүтцийг харахад эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт эрэгтэйчүүдийнхтэй бараг адил юм. Үүнийг 2002 оны ажиллагчдын нас, хүйсний бүтцийн график харуулж байна (Зураг 3). Гэхдээ зарим насны бүлэгт эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс арай илүү байна.




1992-2002 оны байдлаар нийт хүн амын 50-иас дээш хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан бол харин эдгээр хугацааны туршид ажиллах хүчний 51-ээс дээш хувийг эрэгтэйчүүд эзэлж байна (1992 онд 51.9 хувь, 2002 онд 50.4 хувь нь эрэгтэйчүүд). Эндээс үзэхэд эрэгтэй хүмүүсийн

ажил эрхлэлтийн түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна (Ажил эрхлэлтийн түвшинг хүйсээр нь аймаг, нийслэлээр харуулсан Зураг 4-өөс харж болно). Энэ нь хөдөлмөрийн насны суралцагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр (2002 оны байдлаар нийт суралцагчдын 54.4 хувь нь эмэгтэйчүүд) байгаатай холбоотой юм.

Ажил эрхлэлтийн түвшин 2002 онд 60.5 болж, өнгөрсөн оныхоос 2 хувиар өссөн нь төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хуулиуд батлагдан шинээр ажлын байр бий болж, ажиллагчдын тоо өссөнтэй холбоотой.

Ажил эрхлэлтийн түвшинг хүйсээр нь аймаг, нийслэлээр авч үзэхэд Дархан-Уул аймагт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин ойролцоо, харин бусад бүх аймагт эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байна.



2002 оны байдлаар Өмнөговь, Дундговь, Сүхбаатар, Завхан, Өвөрхангай, Говь-Алтай, Увс, Архангай аймагт ажил эрхлэлтийн түвшин улсын дунджаас харьцангуй өндөр байхад, Дархан-Уул, Дорнод аймаг, Улаанбаатар хотод харьцангуй бага 11.1–19.5 хувиар доогуур байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 5. Хүн амын ажил эрхлэлтийн түвшин, аймаг, нийслэлээр (хувиар)

Аймаг, нийслэл	1999	2000	2001	2002	Өсөлт, бууралт (%)		
					2002	2002	2002
					1999	2000	2001
Архангай	74.9	75.0	73.6	73.7	98.3	98.2	100.1
Баян-Өлгий	68.4	62.5	62.3	64.4	94.2	102.9	103.4
Баянхонгор	78.1	77.3	74.5	65.6	83.9	84.9	88.0
Булган	64.5	68.4	63.6	64.8	100.4	94.7	101.9
Говь-Алтай	77.3	77.2	74.2	74.3	96.2	96.3	100.1
Дорноговь	62.4	63.1	65.5	64.6	103.4	102.4	98.6
Дорнод	43.1	41.1	40.6	42.1	97.6	102.5	103.7
Дундговь	81.3	79.8	78.0	77.6	95.5	97.2	99.5
Завхан	75.1	75.1	73.8	74.8	99.6	99.6	101.4
Өвөрхангай	81.6	81.9	77.8	74.4	91.2	90.9	95.7
Өмнөговь	88.0	87.5	86.5	80.2	91.1	91.6	92.6
Сүхбаатар	73.6	74.0	74.3	75.3	102.3	101.8	101.4
Сэлэнгэ	59.7	58.3	59.7	62.6	104.9	107.4	104.8
Төв	65.0	70.8	73.3	74.0	113.9	104.6	101.0
Увс	68.1	73.6	74.7	74.2	109.0	100.8	99.3
Ховд	67.7	69.0	66.1	67.1	99.1	97.2	101.5
Хөвсгөл	74.4	71.8	70.3	70.0	94.1	97.6	99.6
Хэнтий	60.2	63.5	64.5	65.0	108.1	102.4	100.8
Дархан-Уул	48.9	42.1	44.0	41.0	83.9	97.6	93.4
Улаанбаатар	52.7	44.9	44.6	49.4	93.8	110.0	110.7
Орхон	69.2	66.0	63.6	61.2	88.5	92.6	96.2
Говьсүмбэр	52.1	55.5	50.3	51.6	99.1	92.9	102.6
Улсын дундаж	63.6	60.0	59.3	60.5	95.1	100.8	102.0

Эх сурвалж: ҮСГ, 2002


2002 онд ажил эрхлэлтийн улсын дундаж түвшин өссөн ч гэсэн Хөвсгөл, Дундговь, Увс, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Дархан-Уул, Өмнөговь, Баянхонгор аймгуудад ажил эрхлэлтийн түвшин 0.4-12.0 хувиар буурсан байна. Харин Улаанбаатар хотод ажил эрхлэлтийн түвшин өмнөх оноос 10.7 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 6. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	1999	2000	2001	2002	Өсөлт, бууралт (%)		
					2002	2002	2002
					1999	2000	2001
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	402444	393331	402218	391136	97.2	99.4	97.2
Загас ангуур	196	172	210	290	148.0	168.6	138.1
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	18949	18644	19920	23766	125.4	127.5	119.3
Боловсруулах аж үйлдвэр	58530	54579	55608	55566	94.9	101.8	99.9
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	21275	17762	17756	19828	93.2	111.6	111.7
Барилга	27622	23444	20413	25524	92.4	108.9	125.0
Бөөний жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	83083	83859	90304	104533	125.8	124.7	115.8
Зочид буудал, зоогийн газар	16103	13332	16504	20864	129.6	156.5	126.4
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	34908	34134	35097	38807	111.2	113.7	110.6
Санхүү, зээлийн байгууллага	7724	6802	7338	9353	121.1	137.5	127.5
Үл хөдлөх хөрөнгө, бизнес үйл ажиллагаа	5043	7204	6819	10910	216.3	151.4	160.0
Төрийн байгууллагын үйл ажиллагаа	31539	34703	41013	43951	139.4	126.6	107.2
Боловсрол	43152	54440	55244	59266	137.3	108.9	107.3
Эрүүл мэнд, нийгмийн халамж	34759	33502	33015	34478	99.2	102.9	104.4
Нийгмийн болон хувийн үйлчилгээ	25145	28983	26861	27510	109.4	94.9	102.4
Бусад	3087	4099	3991	4999	161.9	122.0	125.3


Тайлбар* Гадаадад гэрээгээр болон ГХЯ-ны шугамаар ажиллаж байгаа хүмүүс ороогүй
Эх сурвалж: УСГ, 2002

1999 онтой харьцуулахад 2002 онд хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж, барилга, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарынхаас бусад бүх салбарт ажиллагчдын тоо өссөн, нэн ялангуяа үл хөдлөх хөрөнгө, бизнесийн салбарт ажиллагчдын тоо 2 дахин нэмэгдсэн байна. Харин 2001 онтой харьцуулахад хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, боловсруулах аж үйлдвэрийн салбараас бусад бүх салбарт ажиллагчдын тоо 2.4-60.0 хувиар өсчээ.




2002 онд нийт ажиллагчдын 44.9 хувь нь хөдөө аж ахуйн, 11.4 хувь нь аж үйлдвэрийн, 12 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллаж байв (Зураг 5).

Хөдөө аж ахуй ДНБ-д 33.0 хувийг эзэлж байхад, ажиллагчдын 44.9 хувь нь энэ салбарт ажиллаж байна. Гэтэл аж үйлдвэр ДНБ-д 20.0 хувь эзэлж байхад энэ салбарт ажиллагчид нийт ажиллагчдын 11.4 хувийг эзэлж, илүү өндөр бүтээмжтэй салбар болохоо харуулж байна.




Эрүүл мэнд, боловсрол, зочид буудал, зоогийн газар, худалдаа болон боловсруулах аж үйлдвэрийн салбарт эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Харин уул уурхай, олборлох аж үйлдвэр, цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэл, усан хангамж, тээвэр, холбоо, барилга, төрийн захиргаа, батлан хамгаалахын салбарт эрэгтэйчүүдийн эзлэх хувь нь эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байна (Зураг 6).


2002 оны нийт ажиллагчдын 14 хувь буюу 121.7 мянга нь дээд, 11.1 хувь буюу 96.7 мянга нь тусгай мэргэжлийн дунд болон бүрэн бус дээд, 8.9 хувь буюу 77.8 мянга нь мэргэжлийн анхан шатны, 53.5 хувь буюу 465.7 мянга нь бүрэн ба бүрэн бус дунд, 10.6 хувь буюу 92.7 мянга нь бага боловсролтой, 1.9 хувь буюу 16.2 мянга нь боловсролгүй хүмүүс байгаа нь Зураг 7-оос харагдаж байна.



Дээд болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажиллагчдын дунд эмэгтэйчүүд харьцангуй өндөр хувийг, харин мэргэжлийн анхан шатны боловсролтой ажиллагчдын дотор эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байна (Зураг 8). Бүрэн дундаас доош боловсролтой ажиллагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс 1.8-12.3 пунктээр илүү байна. Боловсролгүй ажиллагчдын 55.6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.



Ажиллагчдыг тэдний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагынх нь өмчийн хэлбэрийг харгалзан ангилж гаргалаа. Төрийн - Монгол улсын, төрийн -гадаадтай хамтарсан өмчтэй аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдыг төрийн өмчийн байгууллагад ажиллагчид гэж үзэхэд энд ажиллагчид нийт ажиллагчдын 23.3 хувийг эзэлж байна. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагад нийт ажиллагчдын 3.3 хувь нь ажиллаж байна.



Нийт ажиллагчдын 72.2 хувь нь хувийн өмчийн байгууллагад, 1.2 хувь нь гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагад тус тус ажиллаж байна. Энэ бүтэц ДНБ-ний бүтэцтэй ойролцоо, тухайлбал 2001 онд ДНБ-ий 75 хувийг нь хувийн секторт бүтээж байсантай төстэй байна.

2002 оны эцэст хөдөлмөр эрхлээгүй хүний тоо 265.8 мянга болж, 2001 оныхоос 4.7 хувиар буурчээ. Хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүний 32 хувьтай тэнцэх хүн 2001 онд хөдөлмөр эрхлээгүй байсан бол 2002 онд энэ үзүүлэлт 29.5 хувь болж буурсан байна. Энэ бол ажилгүйдлийг бууруулах чиглэлээр ахиц өөрчлөлт гарч байгааг харуулж байна.

ҮСГ-ын дарга, НХХ-ийн сайдын 2002 оны 207/203 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хүн амын хөдөлмөр эрхлэлт болон ажиллах хүчний тухай үндсэн ойлголт, тодорхойлолт”-ын дагуу хөдөлмөр эрхлээгүй хүн амд хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин, хөлс, орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тодорхой шалтгаангүй г.м) шалтгаанаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн амыг хамруулсан. Гэхдээ эдгээрт бүх шатны сургуульд өдрөөр суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүмүүс ороогүй.

Харин дээрх хамтарсан тушаалаар батлагдсан ойлголт, тодорхойлолтын дагуу зохих зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүйг нь харгалзахгүйгээр хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн амд хамруулан гаргасан нь 2002 оны ажиллагчдын тооны өсөлт болон хөдөлмөр эрхлээгүй хүн амын тооны бууралтанд зохих нөлөө үзүүлсэн болно.

Хөдөлмөр эрхлээгүй хүний тоо 2002 онд өмнөх оноосоо Сүхбаатар, Ховд, Төв, Сэлэнгэ, Булган, Хэнтий, Дундговь, Архангай аймаг, Улаанбаатар хотод 2.7-23.9 хувиар буурч, харин бусад аймгуудад 18.8–56.2 хувиар өссөн байна. Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл, Баян-Өлгий, Орхон аймаг, Улаанбаатар хотод хөдөлмөр эрхлээгүй хүний тоо харьцангуй өндөр байна. Нийт хөдөлмөр эрхлээгүй хүний 39.2 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Хүснэгт 7. Хөдөлмөр эрхлээгүй хүний тоо, аймаг, нийслэлээр

	1999	2000	2001	2002	Өсөлт, бууралт (%)		
					<u>2002</u>	<u>2002</u>	<u>2002</u>
					1999	2000	2001
Архангай	5741	4970	7205	7013	122.2	141.1	97.3
Баян-Өлгий	8606	11697	9559	9993	116.1	85.4	104.5
Баянхонгор	4631	4870	6415	9577	206.8	196.7	149.3
Булган	6487	6144	6848	6423	99.0	104.5	93.8
Говь-Алтай	3326	3114	3914	4662	140.2	149.7	119.1
Дорноговь	6618	6595	6194	6266	94.7	95.0	101.2
Дорнод	14572	15507	14468	15437	105.9	99.5	106.7
Дундговь	1930	1471	1802	1737	90.0	118.1	96.4
Завхан	3485	3432	5279	5321	152.7	155.0	100.8
Өвөрхангай	2589	2703	4298	6715	259.4	248.4	156.2
Өмнөговь	1295	1344	1745	1863	143.9	138.6	106.8
Сүхбаатар	3058	3419	2381	1811	59.2	53.0	76.1
Сэлэнгэ	12048	13717	13706	12816	106.4	93.4	93.5
Төв	12549	8278	8232	7432	59.2	89.8	90.3
Увс	8941	6294	5618	5803	64.9	92.2	103.3
Ховд	7024	7160	8147	7095	101.0	99.1	87.1
Хөвсгөл	8382	10854	9679	11494	137.1	105.9	118.8
Хэнтий	9431	7572	7908	7588	80.5	100.2	96.0
Дархан-Уул	18368	17804	19023	20625	112.3	115.8	108.4
Улаанбаатар	61487	136222	125601	104164	169.4	76.5	82.9
Орхон	5908	7924	8818	9695	164.1	122.3	109.9
Говьсүмбэр	2081	1631	2104	2281	109.6	139.9	108.4
Дүн	208557	282722	278944	265811	127.5	94.0	95.3

Эх сурвалж: УСГ, 2002

Хөдөлмөр эрхлээгүй бүх хүмүүсийг огт ажилгүй гэж үзэж хараахан хэлж болохгүй. Учир нь эдгээр хүмүүсийн дунд их, бага хэмжээгээр хөдөлмөр эрхэлж орлого олдог (гудамж талбайд наймаа хийх, айлд хөлсөөр ажиллах, хүүхэд асрах, улирлын чанартай ажил хийх) зэрэг хүмүүс байхыг үгүйсгэх аргагүй. Эдгээр хүмүүсийн 49.7 хувь нь урьд нь

ямар нэг ажил хөдөлмөр эрхэлж байсан хүмүүс байна. Хөдөлмөр эрхлээгүй нийт хүний 52.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн тодорхой ажил үйлдвэрлэл эрхэлж чадахгүй байгаа шалтгааныг нь хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаан гэж 2 хувааж авч үзсэн бөгөөд 35.3 хувь нь хүндэтгэх шалтгаанаар, 64.7 хувь нь хүндэтгэх бус шалтгаанаар ямар нэг ажил хөдөлмөр эрхлээгүй байна. Хүндэтгэх шалтгаанд хүүхэд буюу өвчтөн, өндөр настан асардаг (18.1 хувь), өвчтэй (3.6 хувь), гэрийн ажилтай (8.6 хувь), гэр бүлийн хүний ажлын онцлогоос (5 хувь нь) шалтгаалж хөдөлмөр эрхлэхгүй байгаа хүмүүсийг оруулсан. Харин хөдөлмөр эрхлэх сонирхолгүй, ажил хайж байгаа, засан хүмүүжүүлэх газраас суллагдсан, тохирох ажил олдохгүй байгаа болон тодорхой шалтгаангүйгээр ажил хөдөлмөр хийхгүй байгаа хүмүүсийг хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүйд оруулсан.




Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын 22.7 хувь нь ажил хайж байгаа, 13.6 хувь нь тохирох ажил олдохгүйгээс, 2.8 хувь нь хөдөлмөр эрхлэх сонирхолгүйгээс хөдөлмөр эрхлэхгүй байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхэлдэггүй дөрвөн хүн тутмын нэг нь буюу 66.7 мянган хүн ямар нэг тодорхой шалтгаангүйгээр ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа нь нэлээд сонирхол татаж байна.

Хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлэхгүй байгаа 172 мянган хүн байгаагийн 35.1 хувь нь ажил хайж байгаа, 21.1 хувь нь тохирох ажил олдохгүй байгаа, 4.3 хувь нь хөдөлмөр эрхлэх сонирхолгүй, 38.8 хувь нь ямар нэг шалтгаангүйгээр хөдөлмөр эрхлээгүй хүмүүс байгаа нь Зураг 11-ээс харагдаж байна.



2002 оны хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг насны бүлгээр нь авч үзвэл нийт хүмүүсийн 46.2 хувийг нь 16-29 насны залуучууд, 17 хувийг 30-34 настай, 14.4 хувийг 35-39 настай, 15.5 хувийг 40-49 настай, 7.7 хувийг 50-59 насны хүмүүс тус тус эзэлж байна (Зураг 12).



Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас гаргасан аргачлалын дагуу ажилгүйчүүд гэдэгт Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, хөдөлмөр эрхлэх боломжтой, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүсийг оруулсан. Гэхдээ зарим тохиолдолд улс орнуудын ажилгүйдлийн түвшин үнэн, зөв тодорхойлогдоогүй байдаг.

Олон улсын нийтлэг аргачлалаар тодорхойлогдсон ажилгүйдлийн түвшинг зарим улс орноор Хүснэгт 8-д үзүүлэв.

Хүснэгт 8. Ажилгүйдлийн түвшин, зарим улс орноор

	1980	1990	1997	1998-2000
Болгар		1.7	13.7	16.3
Унгар		0.8	8.7	6.5
Польш		6.1	11.2	16.7
Румын		3.0	6.0	10.8
ОХУ			11.3	11.4
Франц	6.1	8.9	12.3	10.0
Герман		7.2	9.8	8.1
Швед	2.0	1.6	7.9	5.1
Англи		6.7	8.0	5.3
Өмнөд Солонгос		2.4	2.6	4.1
Филипин	4.8	8.1	7.4	10.1
Япон	2.0	2.1	3.4	4.8

* Эх сурвалж: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд, Дэлхийн банк, 2002

Хуучин төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсан орнуудад 1990 он хүртэл ажилгүйдлийн түвшин тодорхойлогдож байгаагүй, ийм үзэгдэл байхгүй гэж үзэж байсан бөгөөд эдгээр орнууд зах зээлийн эдийн засагт шилжин орсноор ажилгүйдэл цоо шинэ үзэгдэл болж, үүнийг хэмжин тодорхойлж, улс орны эдийн засгийн бодлогод оролцуулан тооцох шаардлага урган гарсан.


Хүснэгт 9. Ажиллах хүчин, ажилгүйдлийн түвшин

	1999	2000	2001	2002
Ажиллах хүчин, мян.хүн	853.4	847.6	872.6	901.7
Ажилгүйчүүд, мян.хүн	39.8	38.6	40.3	30.9
Ажилгүйдлийн түвшин, %	4.7	4.6	4.6	3.4

Эх сурвалж: ҮСГ, 2002


Ажилгүйдлийн түвшин сүүлийн жилүүдэд буурч байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо буурсантай холбоотой. 2002 онд ажилгүйдлийн түвшин 3.4 хувь болж, 2001 оноос 1.2 пунктээр буурсан нь нэг талаар хөдөлмөр эрхлэлтийн албанд шинээр бүртгүүлэгчдийн тоо нэмэгдсэн ч гэсэн бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон болон бүртгэлээс хасагдсан хүний тоо ихэссэнтэй холбоотой.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2002 оны эцэст 30.9 мянга болж, өнгөрсөн оныхоос 23.5 хувь буюу 9.5 мянган хүнээр буурлаа. 2002 оны туршид 45.3 мянган хүн хөдөлмөр эрхлэлтийн албанд шинээр бүртгүүлсэн нь өнгөрсөн оныхоос 32 хувь, бүртгэлтэй ажилгүйчүүдээс 35.5 мянган хүн ажилд орсон нь өнгөрсөн оныхоос 36.5 хувиар тус тус нэмэгдсэн байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 54.4 хувь нь эмэгтэйчүүд байна




Эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажиллагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс бага байсан бол бүртгэлтэй ажилгүйчүүдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байна.

2002 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн 8.8 хувь нь дээд, 10.9 хувь нь тусгай дунд, 12.2 хувь нь мэргэжлийн анхан шатны, 62.4 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд, 5.0 хувь нь бага боловсролтой, 0.7 хувь нь боловсролгүй хүмүүс байна (Зураг 14).



Хөдөлмөрийн насны 10 мянган хүн амд ногдох ажилгүйчүүдийн тоо улсын дунджаар 220 байгаатай зэрэгцүүлэхэд Дорноговь (149), Сэлэнгэ (151), Төв (163) аймаг, Улаанбаатар (102) хотод нилээд бага, харин Завхан (369), Говь-Алтай (383), Баянхонгор (517) аймагт харьцангуй өндөр байна.

2002 оны ажилгүйдлийн түвшинг хүйсээр нь аймаг, нийслэлээр эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшингийн багаас нь их рүү жагсааж дараах Зураг 15-д харуулав.



Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Увс, Завхан аймгуудаас бусад бүх аймаг, хотод эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Нэн ялангуяа Орхон, Дорнод, Дархан-Уул, Булган, Дундговь, Хэнтий аймгуудад эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс бараг 1.5-2.2 дахин их байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн болон ажилгүйдлийн түвшний хоорондох хамаарлыг илэрхийлсэн Оукены хуулийн дагуу ажилгүйдлийн түвшин байх ёстой хэмжээнээсээ 1 хувь ихэсвэл дотоодын нийт бүтээгдэхүүний алдагдсан боломж 2 хувь байдаг.

Хүснэгт 10. Ажилгүйдлээс болж алдагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, 1995 оны зэрэгцүүлэх үнээр

	1995	1999	2000	2001	2002
ДНБ, сая төгрөг	550253.7	624723.2	632521.5	639013	664252.5
Ажилгүйдлийн түвшин (%)	5.5	4.7	4.6	4.6	3.4
Боломжит ДНБ, сая төгрөг	574464.9	642215.4	648967.1	655627.3	665581.0
Алдсан боломж, сая төгрөг	24211.2	17492.2	16445.6	16614.3	1328.5

Эх сурвалж: ҮСГ, 2002

Монгол Улсын ажилгүйдлийн байж болох зохимжит түвшин нь 3.3 хувь гэж үзвэл 1995 оны зэрэгцүүлэх үнээр 1999 онд 17492.2 сая төгрөг, 2000 онд 16445.6 сая төгрөг, 2001 онд 16614.3 сая төгрөг, 2002 онд 1328.5 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжоо алдсан байна.

Дүгнэлт

1. Манай улс ажиллах хүчнийхээ 95.3 хувийг 1999 онд ашиглаж байсан бол 2002 онд 96.6 хувийг ашиглах болж 1.3 пунктээр нэмэгдсэн байна.
2. Ажил эрхлэлтийн түвшин 2002 онд 60.5 болж 2001 оныхоос 1.2 хувиар өссөн нь төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хуулиуд батлагдан шинээр ажлын байр бий болж ажиллагчдын тоо өссөнтэй холбоотой.
3. Эдийн засгийн салбарт ажиллагчдын тоог ДНБ-ний өсөлттэй уялдуулан авч үзэхэд бүтээгдэхүүний өсөлт бүхий салбарын ажиллагчдын тоо нэмэгдсэн байна. Жишээ нь: уул уурхай, олборлох аж үйлдвэр, цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж, барилга, бөөний, жижиглэн худалдаа, тээвэр, холбооны салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон ажиллагчдын тоо хоёул нэмэгдсэн байна.
4. Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн ДНБ-нд 33.0 хувийг эзэлж байхад, нийт ажиллагчдын 44.9 хувь нь энэ салбарт ажиллаж байна. Гэтэл аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн ДНБ-нд 20.0 хувь эзэлж байхад энэ салбарт ажиллагчид нийт ажиллагчдын 11.4 хувийг эзэлж, илүү өндөр бүтээмжтэй салбар болохоо харуулж байна.
5. Хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүний 25.6 хувьтай тэнцэх хүн 1999 онд хөдөлмөр эрхлээгүй байсан бол 2002 онд энэ үзүүлэлт 30.5 хувь болж өссөн нь анхаарал татаж байна